

Сүмийн түүх болон Сургаал ба Гэрээнүүдэд гардаг дотно холбоо харилцааны жишээ

1-р жишээ

Иосеф Смит 1823 оны 9-р сард Кумора гүвээнд очсоныхоо дараа өөрт тохиолдсон явдал болон тэнгэр элч Моронайн үзэгдлийг гэрийнхэнтэйгээ хуваалцжээ. Иосеф хамгийн ойр дотно хүмүүстэйгээ өөрт тохиолдсон явдал, үзэгдлийг хуваалцсаар байв. Бошиглогчийн ээж Люси Мак Смит эдгээр ариун нандин уулзалтыг дурсан ийн тэмдэглэн үлдээжээ.



Бид орой бүр хүүхдүүдээ цуглуулдаг байлаа. Аав, ээж, хөвгүүд, охид бүгд суудлаа эзэлж, . . . хөвгүүний заадаг шашны сургаалуудыг амьсгаа даран сонсдог байсан нь энэ хорвоо дээр аж төрж байсан гэр бүлийн хамгийн өвөрмөц төрх байдлыг харуулсан гэж би боддог. . . .

. . . Ер бусын бат бөх эв нэгдэл, аз жаргал манай гэрт ноёрхдог байлаа. Амар амгаланг маань эвдэн бусниулагч хэрүүл маргаан, санал зөрөлдөөний аль аль нь бидний дунд байсангүй. (Люси Мак Смит, *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 486)

- Энэ түүхээс Смитийн гэр бүлийн талаар юу нь танд хамгийн чухал санагдаж байна вэ?
- Иосефын гэртээ байхдаа мэдэрсэн хайр чухал дуудлагаа биелүүлэхэд нь түүнд хэрхэн тусалсан байж болох вэ?
- Энэ жишээнээс Бурхан таныг хэрхэн адисалж болох мөн та дотно холбоо харилцаагаар дамжуулан бусдыг адислахад нь хэрхэн тусалж болох талаар юу сурсан бэ?

2-р жишээ

Иллинойс мужийн Науву хотод амьдарч байхдаа Иосеф Смит дотно холбоо харилцааны ашиг тусын талаар эргэцүүлж байв.



Үүнийг би агуу адислалуудын нэг хэмээн үзнэ. Би энэ дэлхийд зовох хувь тавилантай ч ахан дүүс, анд нөхдийг хаа сайгүй эргэн тойрноосоо олж чадна. (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, 466)

- Хэцүү сорилтуудтай тулгарах үед гэр бүл, найз нөхөд бидэнд хэрхэн туслах вэ?
- Гэр бүл, найз нөхөд бидний амьдралыг өөр ямар арга замаар адисалж болох вэ?

3-р жишээ

Сургаал ба Гэрээнүүд 108:7-г уншаад, Далын ахлагч Лайман Шерманд өгсөн Их Эзэний зөвлөгөөг олж мэд.

- Энэ зөвлөгөөг дагахад яагаад заримдаа хэцүү байдаг вэ?
- Та нар хэзээ өөр нэгэнтэй харилцсанаар хүчирхэгжиж, өөдрөг болсон бэ?